

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015.01.20

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг

НЭГ. АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ХАНГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон харьяа нэгж байгууллагын нийт 113 албан хаагчдын Хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг ХАСХОМ1, ХАСХОМ2 дугаар маягтаар гарган 2014 оны 01/139 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ.

Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг боловсруулан Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан С.Баярцэцэгт хянуулж, дүүргийн Засаг даргын 2014 оны А/57 дугаар захирамжаар батлуулан хэрэгжүүлж биелэлтийг 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1232 тоот албан бичгээр АТГ болон НЗДТГ-т тус тус хүргүүлсэн. Тус төлөвлөгөөнд тусгасны дагуу Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах ажлын хүрээнд дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний танхимд Ухаалаг самбар байрлуулах ажлыг хэрэгжүүлснээр уг ажил нь АТГ-аас жил бүр шалгаруулдаг “Сайн туршлага” номинацид нэр дэвшин шалгарсан.

Авлигын эсрэг хуулийг сурталчлах ажлын хүрээнд АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Балдандоржтой хамтран 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр тус дүүргийн 9, 12, 14, 16 дугаар хороодын 34 хэсгийн ахлагч нарын дунд Авлигын эсрэг сургалтыг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газраас өгсөн Шалган туслах ажлын удирдамж, сургалтын хуваарийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх 53 хэлтэс алба байгууллагад хүргүүллээ. Сургалтын хуваарийн дагуу 2014 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 09.00-10.30 минутад Засаг даргын Тамгын газар, Боловсролын хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Дотоод аудитын алба, Статистикийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба, Өмч газрын харилцааны алба, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв зэрэг 9 байгууллагын 38 албан хаагчдад, 26-ны өдөр 11.00-12.30 минутад Эрүүл мэндийн нэгдэл, Нийгмийн даатгалын хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс,

Мэргэжлийн хяналтын хэлтэс, Биеийн тамир, спортын хороо зэрэг 6 байгууллагын 21 албан хаагчдад Авлигатай тэмцэх газрын УССГХэлтсийн ажилтан А.Дэлгэрбаяр Б.Туул нар сургалт хийлээ.



2014 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр дүүргийн ЕБС, СӨБ байгууллагуудын захирал, эрхлэгч нарын дунд мөн 1, 2, 11 дүгээр хороодын 28 иргэний дунд сургалт зохион байгуулсан.

Сүүлийн өдөр буюу 29-ний өдөр хороодын Засаг дарга, Нийгмийн ажилтнууд, орон нутгийн өмчит байгууллагын дарга нарын дунд сургалт зохион байгууллаа. Уг сургалтанд 35 хүн хамрагдсан байна.



Энэ удаагийн сургалт нь оролцооны аргад тулгуурлан харилцан ярилцах, асуулга бөглөж түүн дээрээ дүн шилжилгээ хийх зэрэг аргуудыг хэрэглэснээрээ онцлог байлаа.

Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөө, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Засаг даргын Тамгын газар, хороо, ИТХ-ын Ажлын албаны нийт 85 төрийн захиргааны албан хаагчдад “Хөрөнгө орлогын мэдүүлэг” сэдэвт сургалтыг Авлигатай тэмцэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажилтан Анхныбаяртай хамтран зохион байгууллаа.

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд 2014 онд байдлаар Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн хүний нөөцийн холбогдолтой нийт 106 өргөдөл, гомдлыг Smart city програмаар хүлээн авч судлан шийдвэрлэж холбогдох эзэнд нь хариуг өгч ажиллалаа.

Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын 2014 оны 01/151 тоот албан бичгээр Санхүү, төрийн сангийн хэлтсийн Орлогын эдийн засагч, Нийгмийн хөгжлийн хэлтсийн Эрүүл мэнд, биеийн тамир, соёл урлаг хариуцсан мэргэжилтэн, Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн Цахилгаан, дулаан, цэвэр бохир ус хариуцсан мэргэжилтний албан тушаалын сул орон тооны захиалгыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн.

Эдгээр 3 албан тушаалын сул орон тооны захиалгад байсан Нийгмийн хөгжлийн хэлтсийн Эрүүл мэнд, биеийн тамир, соёл урлаг хариуцсан мэргэжилтнийг Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцөөс бүрдүүлсэн бөгөөд уг ажлын байранд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт зарлах шаардлагагүй болсон тул Санхүү, төрийн сангийн хэлтсийн Орлогын эдийн засагч, Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн Цахилгаан, дулаан, цэвэр бохир ус хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт зарлуулах саналаа 01/249 тоот албан бичгээр хүргүүлсний дагуу уг сул орон тооны зарыг өөрийн цахим хуудас болон Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст холбогдох журмын дагуу байршуулж, 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр уг шалгалтыг зохион байгуулсан байна. Мөн 2014 оны 12 дугаар сарын 20-нд 12 дугаар хорооны Зохион байгуулагчийн сул орон тооны захиалгыг хүргүүлж, цахим хуудасны Хүний нөөцийн ил тод байдал цэсний Сул орон тооны мэдээлэл буланд байршуулсан.

ГУРАВ. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 2014 ОНЫ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТАЛААР ИРГЭД ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ

Тус дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь 2014 онд Нийслэлээс эрх шилжүүлсэн болон дүүргийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Худалдан авах ажиллагааны албанаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан 9.6 тэрбум төгрөгийн 115 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн. Үүнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 4, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 23, нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 5, дүүргийн төсвийн хөрөнгөөр 20, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 54, өмнөх оны дүүргийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хэмнэгдсэн хөрөнгөөр 7, Улсын төсвийн хөрөнгөөр 2 ажил, хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99 төсөл арга хэмжээг www.khanuul.mn, www.e-procurement.mn, www.meps.gov.mn

цахим хуудаст тендерийн урилга, зарыг байршуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороо, Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Эдгээр 99 ажлаас 2 ажил дараа онд үргэлжлэн хэрэгжихээр болсон.

Нийт 99 ажил дээр тендерийг зарлан урилгыг цахим хаяг болон өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлсэн байна. “Өдрийн сонин”, “Нийслэл таймс” сонинд нийт 11 удаа, www.khanuul.mn, www.e-procurement.mn, www.meps.gov.mn сайтаар 46 удаа зарласан байна.



Тендерийн нээлтэнд оролцогч ААНБ-ыг нээлттэй оролцуулж тендерийн баримт бичгийн эх хувийг лацдаж баталгаажуулан ажиллаж байна.



Цахим худалдан авах ажиллагаа төслийн хүрээнд тендерийн баримт бичгийг CD хэлбэрээр худалдаалж эхэлсэн. Жагсаалтын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдаж авч буй бараа, ажил, үйлчилгээний нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг албан ёсоор www.e-procurement.mn, www.khanuul.mn сайтууд болон Өдрийн сонин, Нийслэл таймс зэрэг сонингуудад тогтмол мэдээлж байна.



2014 оны 05 дугаар сарын 21-ний өдөр “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд иргэд, иргэдийн бүлгийн оролцоо” сэдэвт арга барил, туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 9 дүүргийн иргэд, иргэдийн бүлгийн 80-аад хүний бие төлөөлөлд энэ онд хийгдэх төсөл арга хэмжээг танилцуулж, тендерийн баримт бичиг бэлтгэх ажиллагаанд нь мэдээлэл зөвлөгөө өгч, тулгамдаж буй асуудлыг хэлэлцсэн.



Мөн өөрийн албаны мэдээллийн самбараар дамжуулан хамгийн сүүлд зарлагдсан тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүн, 2014 онд санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, оролцогч компаниудад өгөх зөвлөгөө зэрэг мэдээллийг байршуулан иргэд, олон нийтэд тогтмол мэдээлж

байна.

